



# СОЁМБОМ ЭДЭЭ

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№198 /408/

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2022.11.03

Цаг үе, үйл явдал

## БРИГАДЫН ГЕНЕРАЛ СҮНРЭВИЙН ГАНБЯМБА ЗХЖШ-ЫН ДАРГААР ТОМИЛОГДЛОО



Өнөөдөр Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч У.Хүрэлсүхийн зарлигаар Зэвсэгт хүчний Жанжин штабын даргаар бригадын генерал С.Ганбямба томилогдож үүрэгт ажлаа хүлээн авлаа.

Уг үйл ажиллагаанд Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Я.Содбаатар, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Аюулгүй байдал, Батлан хамгаалах бодлогын зөвлөх бэлтгэл дэслэгч генерал Ц.Тогоо, Зэвсэгт хүчний Жанжин штаб, төрлийн цэргийн командлал, удирдах газрын удирдлага, бие бүрэлдэхүүн оролцлоо.

Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга дэслэгч генерал Д.Ганзориг шинэ албан тушаалд томилогдож байгаатай холбогдуулан Монгол Улсын Ерөнхийлөгч хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд бригадын генерал Сүнрэвийн Ганбямбыг ЗХЖШ-ын даргаар томилох асуудлыг зөвшилцөх тухай албан бичгийг энэ сарын 1-нд УИХ-д хүргүүлсэн. УИХ-ын чуулганы өнөөдрийн хуралдаанаар Ерөнхийлөгчийн саналыг дэмжсэн тул бригадын генерал С.Ганбямбыг энэхүү албан тушаалд томилох зарлиг гаргасан юм.

Дэслэгч генерал Д.Ганзориг, шинээр томилогдож буй ЗХЖШ-ын

дарга бригадын генерал С.Ганбямба нарт Ерөнхийлөгчийн Тамгын газрын Төрийн цэргийн байгууллагуудын асуудал хариуцсан ахлах референт хурандаа Т.Буянбат “ЗХЖШ-ын даргыг томилсон тухай” Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн зарлигийг уншиж танилцуулав. Үүний дараагаар тэд Зэвсэгт хүчний Жанжин туганд хүндэтгэл үзүүлээ.

Энэ үеэр Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Я.Содбаатар хэлсэн үгэндээ “Юуны өмнө ЗХЖШ-ын даргын өндөр хариуцлагатай албыг нэр төртэй хашиж, Зэвсэгт хүчний хөгжил дэвшилд үнэтэй хувь нэмрээ оруулсан дэслэгч генерал Д.Ганзоригт Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн өмнөөс болон хувиасаа талархал илэрхийлье. ЗХЖШ-ын даргаар томилогдсон бригадын генерал С.Ганбямба нь цэргийн бүх шатны сургуулийг төгссөн, Зэвсэгт хүчинд тасралтгүй 30 дахь жилдээ ажиллаж буй мэргэшсэн, туршлагатай, төрийн албаны мерит зарчмын дагуу дэвшин томилогдож буй дээд офицер гэдгийг Та бүхэн мэдэж байгаа. Өнөөдөр Зэвсэгт хүчинд тулгамдаж буй олон асуудлууд бий. Энэ талаар Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч хэд хэдэн

тодорхой үүрэг, чиглэл өгч, биелэлтийг нь илтгэхийг даалгасан. ЗХЖШ-ын даргаар ЗХЖШ-ын нэгдүгээр орлогч даргыг дэвшүүлэн томилж буй нь Зэвсэгт хүчний хөгжлийн бодлого, үйл ажиллагааны зарчимч чанарыг хадгалах, удирдлагын нэгдмэл байдлыг хангах зорилготой юм” гэдгийг онцоллоо.

Зэвсэгт хүчний Жанжин штабын даргаар томилогдсон бригадын генерал С.Ганбямба нь 1975 онд Улаанбаатар хотноо төрсөн, 1983-1993 онд Нийслэлийн 33 дугаар дунд сургууль, 1993-1997 онд Цэргийн их сургуульд суралцаж “Артиллерийн команд-тактик”-ийн мэргэжил эзэмшин цэргийн ухааны бакалаврын зэрэг, 2007-2009 онд Батлан хамгаалахын удирдлагын академид суралцан “Стратеги-тактик, команд штаб”-ын мэргэжил эзэмшиж, цэргийн ухааны магистрын зэрэгтэй “Онцгойлох үнэлгээтэй” төгссөн.

2017-2019 онд Оросын Холбооны Улсын Зэвсэгт хүчний Жанжин штабын академид “Төрийн цэргийн аюулгүй байдал” мэргэжлээр суралцаж төгссөн бөгөөд одоо Үндэсний Батлан хамгаалахын Их Сургуулийн докторантурт суралцаж байна.

Бригадын генерал С.Ганбямба нь Бүгд Найрамдах Турк Улсад 2003 онд Энхийг сахиулах ажиллагааны

анхан шатны дамжаа, 2006 онд Батальоны захирагчийн дамжаа, 2014 онд Канад Улсад Англи хэлний анхан шатны дамжааг тус тус дүүргэсэн.

Тэр бээр, 1997-2000 онд Зэвсэгт хүчний 120 дугаар ангид салааны захирагч, 2000-2001 онд Зэвсэгт хүчний 120 дугаар ангид батареийн захирагч, 2001-2006 онд Батлан Хамгаалахын Их Сургуулийн Ахлагчийн сургуульд ротын захирагч, 2006-2007 онд Зэвсэгт хүчний 327 дугаар ангид артиллерийн дарга, 2009-2012 онд Батлан Хамгаалахын Удирдлагын Академийн Цэргийн стратегийн тэнхимд багш, ахлах багш, 2012-2013 онд Батлан хамгаалах яаманд тасгийн дарга, ахлах мэргэжилтэн, 2013-2017, 2019-2020 онд Батлан хамгаалах яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газарт Орон нутгийн хамгаалалт, улсын дайчилгааны хэлтсийн дарга, 2020-2021 онд Батлан хамгаалах яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, 2021 оны 9 дүгээр сараас Зэвсэгт хүчний Жанжин штабын нэгдүгээр орлогч даргаар томилогдон ажиллаж байсан юм.

Ө.НАСАНТОГТОХ



### ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 0	☁️ -13


ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 36	☁️ 23

### ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	3,416	3,423
EUR 🇪🇺	3,410	3,430
CNY 🇨🇳	467	469
RUB 🇷🇺	52.30	52.60
JPY 🇯🇵	23.12	23.40
KRW 🇰🇷	2.41	2.43

### ЗУРХАЙ



2022.11.03 /ПҮРЭВ ГАРАГ/  
БИЛГИЙН ТООЛЛЫН 10

**НАМРЫН АДАГ ЦАГААН  
НОХОЙ САР  
ХОЁР ХАР МЭНГЭТЭЙ ЦАГААН  
БИЧ ӨДӨР**

Үс засуулбал:

Эрч хүч ихэснэ

НАРАН УРГАХ, ШИНГЭХ:

07.40-17.32

БАРИЛДЛАГА:

Үл тохирор

ШҮТЭН БАРИЛДЛАГА:

Хүрэлцэхүй

Тухайн өдөр бар, туулай, бич, тахиа жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба үхэр, луу, хонь, нохой жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, луу, могой, хонь, нохой болой. Эл өдөр эд эдлэл барагдах, хулгай, дээрмийг дарах тэргүүтэнд махаши тэнгэрээс гаслан ирэх тул хэрэг тус үл бүтнэ, хараал дарах, гал мандал хий зэрэгт сайн. Баруун нүд татвал эд олох, баруун чих хангинавал аймшиг болох, зүүн чих жингэнэвэл жуулчин ирэх, хэрээ дуугарвал зочин ирэх, тагнай загатанал амгалан болох, бие татвал эцэг эх цочих, хөл татвал тэмцэл болно.

### КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 636,271,570

Эдгэрсэн

Нийт: 615,787,145

Нас барсан

Нийт: 6,597,396

Цаг үе, үйл явдал

## АНГИУДЫН ЗАХИРАГЧ НАРТАЙ ЦАХИМ ХУРЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАВ



Зэвсэгт хүчний Барилга-инженерийн цэргийн удирдах газрын дарга хурандаа Х.Батсайхан 11 дүгээр сарын 2-ны өдөр тус газрын харьяа ангиудын захирагч, орлогч нартай цахим хурлыг зохион байгуулав.

Энэхүү цахим хурлын эхэнд Зэвсэгт хүчний Барилга-инженерийн цэргийн удирдах газрын харьяа ангиудын захирагч нар тус тусын ангид хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, цэргийн сургалт бэлтгэл, сэтгэл зүйн хангалт, материал, техникийн хангалт, тулгамдаж буй асуудлын талаар мэдээлэл хийлээ.

Мөн энэ оны ээлжит цэрэг татлагаар ирсэн шинэ дайчидтай зохион байгуулж буй "Албанд дасгах сургалт"-ын зохион

байгуулалт, явц, үр дүн, ахуй хангалтын талаар илтгэв. Үүний дараа Зэвсэгт хүчний Барилга-инженерийн цэргийн удирдах газрын дарга хурандаа Х.Батсайхан цаг үеийн асуудлаар мэдээлэл өгч, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар үүрэг, чиглэл өглөө.

Түүнчлэн ЗХЖШ-ын Хэвлэл мэдээллийн албаны дарга хурандаа Б.Отгонбаяр ЗХЖШ-ын даргын тушаалаар батлагдсан "Зэвсэгт хүчний Хэвлэл, олон нийттэй харилцах журам" болон "Мэдээллийн аюулгүй байдлыг хангах журам"-ын хэрэгжилтийг хангаж ажиллах талаар арга зүйн зөвлөгөө өгч, харилцан санал солилцсон юм.

## ЗЭВСГИЙНХЭН ЦАХИМААР...



ЗХЖШ-ын МТГ-ын даргын тушаалаар Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, салбаруудын зэвсгийн мэргэжлийн офицер, ахлагч нарын цугларалтыг цахимаар зохион байгууллаа.

Цугларалтаар зэвсгийн мэргэжлийн бие бүрэлдэхүүнийг мэргэжлийн удирдлагаар

хангах, зэвсгийн албаны баримт бичгийн хөтлөлт, зэвсэг, галт хэрэглэлийн ашиглалт, арчлан хамгаалалтыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх, 2023 оны үйл ажиллагааны төлөвлөлт, албан үүргээ гүйцэтгэхтэй холбоотой үүрэг даалгавар өгч ажиллалаа.

## ШИНЭ СУРГУУЛИЙН ЖИЛИЙН БОДЛОГО, ЗОРИЛТЫГ ТАНИЛЦУУЛАВ



### Зэвсэгт хүчний 310 дугаар анги

Шинэ сургуулийн жилийн нээлтийг тохиолдуулан ангийн удирдлага, штабын офицерууд, тасаг, албадын дарга нар болон даргалах албан тушаалын ахлагч нартай заах арга зүйн цугларалтыг 10 дугаар сарын 27, 28-ны өдрүүдэд зохион байгуулав.

Энэхүү цугларалтаар шинэ сургуулийн жилийн зорилго, зорилт болон хичээлийн хөтөлбөрүүдийг бие бүрэлдэхүүнд танилцуулахын зэрэгцээ, ҮБХИС-ийн Аюулгүй байдлын дээд сургуулийн багш Б.Дарханцэцэг "Багаар ажиллах чадвар", Монголын гэр бүл судлаачдын мэргэжлийн холбооны

тэргүүн Н.Баясгалан "Гэр бүл төлөвлөлт", МУБИС-ийн Сэтгэл зүйн төвийн багш Ж.Баярхүү "Харилцаа ба хандлага" сэдвээр тус тус лекц уншиж, харилцан ярилцлагыг өрнүүллээ.

Мөн Заах арга зүйн цугларалтын хүрээнд тус ангийн бие бүрэлдэхүүн "БЭСТ ШҮЕС" болон "Хүн од" компани, Техник, технологийн дээд сургуулийн сургалтын үйл ажиллагаатай танилцаж, сургалт, дадлага явуулж буй танхимуудыг үзэж сонирхсон бөгөөд энэ үеэр доктор М.Мөнхцэцэг "Сэтгэл хэмээх ойлголтыг буддын философид авч үзэх нь" сэдвээр яриа таниулга хийсэн юм.

## ГАР НИЙЛЭМЖТЭЙ АЖИЛЛАГААГ ХАНГАХ ЗОРИЛГООР



### Зэвсэгт хүчний 110 дугаар анги

Тус анги 2022-2023 оны заах арга зүйн цугларалтыг 2022 оны 10 дугаар сарын 17, 18-ны өдрүүдэд зохион байгуулсан юм.

Харин тус ангийн зарим бүрэлдэхүүн эх орны бүтээн байгуулалтын ажилд томилогдон оролцож байгаатай холбогдуулан шинэ сургуулийн жилийн нээлтийн ажиллагааг өчигдөр зохион байгууллаа.

Энэ үеэр бие бүрэлдэхүүнийг "Цугларалт" дохиогоор ажиллуулан жагсаалын болон аранз, хувийн зэвсгийн үзлэгийг явуулав. Мөн батлагдсан төлөвлөгөөний дагуу ангийн байрлалаас хөдөлгөөн үйлдэж 10 км-ийн явган маршийг зохион байгуулсан юм.

Маршийн үед бие бүрэлдэхүүнтэй инженер, байр зүй, үй олноор хөнөөх зэвсэг, эмнэлгийн хичээлийн цэгт сургалт, дадлагыг явуулсны үр дүнд тэдний

ур чадвар, цэргийн хэргийн дадлагыг дээшлүүлэв.

Мөн бие бүрэлдэхүүний гар нийлэмжтэй ажиллагаа, багаар ажиллах чадварыг нэмэгдүүлэх, нөхөрсөг уур амьсгалыг бүрдүүлэх зорилгоор маршийн түр амралтын үед олс таталтын тэмцээнийг зохион байгуулж, аваргуудаа тодруулсан юм.

Ахмад Т.МӨНХ-ЭРДЭНЭ

## СУРГАЛТ

### МОНГОЛ БИЧГИЙН ХИЧЭЭЛ №16

7 ЭГШГИЙГ УНШИХ, БИЧИХ /үргэлжлэл/  
Түрүүчийн хичээлээр үзсэн, үгийн эхэнд орох 7 богино эгшгийн бүрэн хэлбэрийг дахин дармал хэлбэрээр нэгтгэн харвал:

ᠠ ᠡ ᠢ ᠣ ᠤ ᠥ ᠦ

Бичмэлээр үзүүлбэл:

ᠠᠨᠢᠭᠢᠳᠤ ᠲᠠ бүхэн 7 эгшгийн хэлбэрийг бүтэц зурлагаар нь нүдлэн тогтоож, эхэнд ордог А, Э, И, О, У, Ө, Ү гэж аялгуулан уншиж, цэвэр сайхан бичиж сураарай. Одоо, монгол бичиг эхлэн сурч байгаа хүмүүсийн асуудаг зарим зүйлийг товч тайлбарлая.

Юуны өмнө О, У хоёр эгшиг, Ө, Ү хоёр эгшгийг монгол бичигт яагаад адилхан бичдэг вэ? Монгол бичиг бол монгол хэлний олон аялгууны нийтлэг шинжийг хадгалсан зөв бичихзүйтэй тул нутаг нутагт өөр зуур нь сэлгэж хэлдэг эр О, У, эм эгшиг Ө, Ү тус бүрийг адилхан тэмдэглээд, өөр өөрийнхөөрөө дууддаг. Тухайлбал: foᠢ эгшгийг буриад аялгуунд ихэвчлэн Ү-гээр /нүхүр/, халх аялгуунд Ө-гөөр /нөхөр/ дуудна.